



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

### **ЗОРИЛГО.ШҮҮХЭД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ.**

#### **ЗОРИЛТ 1.ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭНИЙ НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ.**

**Дэд зорилт 1.1.**Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

**Үйл ажиллагаа 1.1.1.**Шүүн таслах ажлын төрлөөр дагнасан танхим байгуулах;

**Үйл ажиллагаа 1.1.2.**Шүүхийн үйл ажиллагаа, эрх зүйн байдалтай холбогдсон хууль тогтоомжийн төслийн талаарх саналаа хууль санаачлагчид хүргүүлэх, бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналаа хууль санаачлагчид уламжлах;

**Үйл ажиллагаа 1.1.3.**Шүүхийн шийдвэр, шүүхийн практик, судалгаанд тулгуурлан Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар гаргах.

**Дэд зорилт 1.2.**Шүүхийн судалгааны чанарыг дээшлүүлэх.

**Үйл ажиллагаа 1.2.1.**Хэргийн судалгааны чанарыг сайжруулах (Тодорхой төрлийн хэргийн тойм, статистикийн судалгаа, Хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэх хэргийн судалгаа, Гомдлын судалгаа, Насжилтын судалгаа, Хяналтын шатны шүүхэд хянан шийдвэрлэсэн хэргийн тойм, судалгаа);

**Үйл ажиллагаа 1.2.2.**Монгол Улсын дээд шүүхийн үйл ажиллагааг дэмжих хиймэл оюун ухааныг хөгжүүлэх, нэвтрүүлэхэд шаардлагатай суурь дэд бүтцийг бэлтгэх, чадавхыг бэхжүүлэх. 1.Монгол Улсын дээд шүүхийн хэрэгцээнд нийцсэн хиймэл оюун ухааны суурь судалгааг хийж, дата дэд бүтцийн шаардлагыг тодорхойлж, хэлбэршүүлэх (30%), 2.Дата боловсруулалт, удирдлагын дэд бүтцийг байгуулж, хиймэл оюун ухааныг сургах, турших орчин бүрдүүлэх (60%), 3.Ахисан түвшний дата аналитикийг хэрэглээ болгож, хиймэл оюун ухааны загварыг сургаж эхлэх (90%), 4.Хиймэл оюун ухааныг туршиж, сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх (100%).

**Үйл ажиллагаа 1.2.3.**Шүүхийн үйл ажиллагаа дахь хуульд заасан судалгааны ажлын чанарын үнэлгээний тогтолцоог нэвтрүүлж хэвшүүлэх. 1.Судалгааны чанарыг үнэлэхэд баримтлах аргачлал, зааврыг баталж үнэлгээг хийж эхлүүлэх (50%), 2.Үнэлгээний суурь түвшинг харгалзан зорилтот түвшинг тогтоох (75%), 3.Шаардлагатай өөрчлөлтүүдийг үнэлгээний тогтолцоонд шинэчлэн оруулах, хэвшүүлэх (100%).

#### **ЗОРИЛТ 2.ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ.**

**Дэд зорилт 2.1.**Шүүхийн шийдвэрийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй, ил тод мэдээлэх арга хэлбэрийг сайжруулах.

**Үйл ажиллагаа 2.1.1.**Шүүхийн шийдвэрийн тойм бэлтгэж нийтлэх, түгээх;

**Үйл ажиллагаа 2.1.2.**Шүүхийн шийдвэрийн хураангуй бэлтгэж нийтлэх, түгээх;

**Үйл ажиллагаа 2.1.3.**Шүүхийн мэдээ, мэдээлэл олон нийтэд нэг сувгаар хүргэх боломжийг бүрдүүлэх. 1.Шүүхийн мэдээллийг дамжуулах дэд бүтцийг байгуулах (80%), 2.Шүүхийн мэдээллийн сувгаар нэвтрүүлэх төрөлжсөн контент бий болгох (100%);

**Үйл ажиллагаа 2.1.4.**Шүүхэд ирсэн хэрэг, маргааны талаарх мэдээллийг олон нийтэд үнэн бодитой мэдээлэх;

**Үйл ажиллагаа 2.1.5.**Монгол Улсын дээд шүүхийн цахим хуудсыг хөгжүүлэх.

**Үйл ажиллагаа 2.1.6.**Шүүхийн мэргэшсэн сэтгүүл зүйг хөгжүүлэх, хамтран ажиллах. 1.Санамж бичиг байгуулах (50%), 2.Шүүхийн мэргэшсэн сэтгүүлчийн сургалтын хөтөлбөр боловсруулах (80%), 3.Сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх (90%), 4.Дээд боловсролын институт дээр мэргэшсэн анги бий болгох (100%);

**Үйл ажиллагаа 2.1.7.**Шүүхийн үйл ажиллагааны талаар олон нийтэд хүргэх мэдээ, мэдээллийн давтамжийг нэмэгдүүлэх.

**Дэд зорилт 2.2.**Шүүх хуралдааны нээлттэй байдлыг хангах.

**Үйл ажиллагаа 2.2.1.**Нээлттэй шүүх хуралдааны шууд дамжуулалтын чанарыг сайжруулах (live stream). 1.Чанарын стандартыг тогтоох (75%), 2.Чанарын стандартыг мөрдүүлэх (80%), 3.Чанарын стандартыг ахиулах (85%), 4.Чанарын стандартыг хэвшүүлэх (90%);

**Үйл ажиллагаа 2.2.2.**Шүүх хуралдааны дууны, дуу-дүрсний бичлэгийн чанар, хадгалалт, аюулгүй байдлыг хангах.

## **ЗОРИЛТ 3.ШҮҮХИЙН БИЕ ДААСАН, ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДЛЫГ ХАНГАХ.**

**Дэд зорилт 3.1.**Шүүхийн бие даасан байдлыг хангах.

**Үйл ажиллагаа 3.1.1.**Шүүхийн бие даасан байдлыг хангахуйц төсвийн төлөвлөлтийг сайжруулах;

**Үйл ажиллагаа 3.1.2.**Шүүхийн стандартын шаардлагад нийцсэн байр, танхимтай болох, тохижуулах, тоног төхөөрөмжөөр хангах;

**Үйл ажиллагаа 3.1.3.**Шүүхийн тээвэр, холбоо, мэдээллийн болон тусгай зориулалтын техник хэрэгслийн хангамжийг сайжруулах;

**Үйл ажиллагаа 3.1.4.**Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх (сургалт, судалгааны чанарыг сайжруулах, шүүхийн мэдээллийн нэгдсэн сувагтай болох, үйл ажиллагааг жигдрүүлэх);

**Үйл ажиллагаа 3.1.5.**Шүүхийн академийн цогцолбор байгуулах. 1.Төсөв боловсруулах, зураг төслийг гаргах (50%), 2.Дэд бүтэц, барилгын ажлыг эхлүүлэх (60%), 3.Дэд бүтэц, барилгын ажлыг дуусгах (80%), 4.Үйл ажиллагааг нь эхлүүлж, жигдрүүлэх (100%);

**Үйл ажиллагаа 3.1.6.**Шүүхийн судалгаа, эрдэм шинжилгээний төв байгуулах. 1.Төсөв боловсруулах, зураг төслийг гаргах (50%), 2.Дэд бүтэц, барилгын ажлыг эхлүүлэх (60%), 3.Дэд бүтэц, барилгын ажлыг дуусгах (80%), 4.Үйл ажиллагааг нь эхлүүлж, жигдрүүлэх (100%).

**Дэд зорилт 3.2.**Шүүгчийн хараат бус байдлыг хангах.

**Үйл ажиллагаа 3.2.1.**Шүүгчийн албаны болон хувийн хараат бус байдалд үнэлгээ хийх;

**Үйл ажиллагаа 3.2.2.**Шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулахаас урьдчилан сэргийлэх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах. 1.Хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлэх (75%), 2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг харгалзан зорилтот түвшинг тогтоох (85%), 3.Шаардлагатай өөрчлөлтүүдийг хөтөлбөрт шинэчлэн оруулах (95%), 4.Хөтөлбөрийг үндэслэн цаашид хэрэгжих тогтвортой механизм бүрдүүлэх (100%);

**Үйл ажиллагаа 3.2.3.** Шүүгчийн халдашгүй байдлыг хамгаалах. 1.Хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлэх (75%), 2.Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг харгалзан зорилтот түвшинг тогтоох (85%), 3.Шаардлагатай өөрчлөлтүүдийг хөтөлбөрт шинэчлэн оруулах (95%), 4.Хөтөлбөрийг үндэслэн цаашид хэрэгжих тогтвортой механизм бүрдүүлэх (100%).

#### **ЗОРИЛТ 4.ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧАНАР, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ.**

**Дэд зорилт 4.1.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чанарыг сайжруулах.

**Үйл ажиллагаа 4.1.1.** Хэргийн хөдөлгөөний удирдлагын нэгдсэн системийн ашиглалт, хяналтыг сайжруулах;

**Үйл ажиллагаа 4.1.2.** Хяналтын шатны шүүхэд цахимаар хэрэг хүлээн авах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

**Үйл ажиллагаа 4.1.3.** Хэргийн материалтай цахимаар танилцах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлэх;

**Дэд зорилт 4.2.** Шүүхийн үйлчилгээний чанарыг сайжруулах.

**Үйл ажиллагаа 4.2.1.** Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаж хугацаа, ажиллагаанд байгаа хэргийн насжилтыг бууруулах;

**Үйл ажиллагаа 4.2.2.** Шүүхийн үйлчилгээ үзүүлэх ээлтэй орчин бүрдүүлэх. 1.Шүүхийн байрыг засварлаж, шилжин байрлах (50%), 2.Шүүхийн үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх (75%), 3.Олон улсын жишигт нийцсэн Шүүхийн музейтэй болох (100%);

**Үйл ажиллагаа 4.2.3.** Шүүхийн архивын үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлэх. 1.Архивын баримтуудыг дижитал хэлбэрт хувиргах, хадгаламжийн нэгжийг дижитал хэлбэрээр авч хэвшүүлэх (50%), 2.Архивын үйлчилгээг цахимаар авах программ хөгжүүлэх (75%), 3.Шүүхийн архивын үйлчилгээг цахимаар өгч хэвшүүлэх (100%);

**Үйл ажиллагаа 4.2.4.** Олон улсын жишигт нийцсэн номын сан байгуулах. 1.Номын сангийн фондын шаардлагатай хэсгийг дижитал хэлбэрт хувиргах (50%), 2.Шинэ ном, сэтгүүл бусад материалуудыг дижиталчлах (70%), 3.Номын сангийн үйлчилгээг цахимаар авах программ хөгжүүлэх (90%), 4.Олон улсын жишигт нийцсэн танхим, хүний нөөц бүхий номын сан ажиллуулах (100%);

**Үйл ажиллагаа 4.2.5.** Цагаатгал болон шүүхийн бүх төрлийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимаар авах боломжийг бүрдүүлэх. 1.Цахим систем хөгжүүлэх (80%), 2.Цагаатгал болон шүүхийн бүртгэлийн үйлчилгээг цахимаар өгч хэвшүүлэх (100%).

**Дэд зорилт 4.3.** Шүүхийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх.

**Үйл ажиллагаа 4.3.1.** Олон улсын мэргэшсэн шүүхийн байгууллагууд болон гадаадын шүүхүүдтэй хамтын ажиллагаа өргөжүүлэх;

**Үйл ажиллагаа 4.3.2.** НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон бусад олон улсын байгууллагуудын дэргэдэх судалгааны хүрээлэн, шүүх засаглалыг бэхжүүлэх нэгжтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх. 1.Өргөн хүрээний тандалт судалгаа хийж хамтын ажиллагаа өргөжүүлэх боломжит хувилбаруудыг тооцож хөтөлбөр боловсруулах (50%), 2.Судалгаанд тулгуурлан боловсруулсан хамтын ажиллагаа хөгжүүлэх хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэн ажиллах (75%), 3.Хөтөлбөрийн хүрээнд үе шаттай үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлэх (90%), 4.Хөтөлбөрийг дүгнэж дахин шинэчлэлт хийх (100%);

**Үйл ажиллагаа 4.3.3.** Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаад улсын Элчин сайдын яамдуудтай үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх. 1.Хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг судалж, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх (50%), 2.Хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа идэвхжүүлэх (75%),

3.Хөтөлбөрийг дүгнэж, шинэчлэлт хийх (90%), 4.Үр ашигтай хамтын ажиллагааг тогтмолжуулах (100%);

**Үйл ажиллагаа 4.3.4.**Олон улсын донор байгууллагуудтай хамтран төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;

**Үйл ажиллагаа 4.3.5.**Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн гадаад харилцааг өргөжүүлэх. 1.Өргөн хүрээний тандалт судалгаа хийж хамтын ажиллагаа өргөжүүлэх боломжит хувилбаруудыг тооцож хөтөлбөр боловсруулах (50%), 2.Судалгаанд тулгуурлан боловсруулсан хамтын ажиллагаа хөгжүүлэх хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэн ажиллах (75%), 3.Хөтөлбөрийн хүрээнд үе шаттай үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлэх (90%), 4.Хөтөлбөрийг дүгнэж дахин шинэчлэлт хийх (100%);

**Үйл ажиллагаа 4.3.6.**Шүүхийн хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд холбогдох төрийн байгууллага, их, дээд сургууль, мэргэжлийн холбоодтой харилцаа тогтоож, хамтран ажиллах. 1.Хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг судалж, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх (50%), 2.Хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа идэвхжүүлэх (75%), 3.Хөтөлбөрийг дүгнэж, шинэчлэлт хийх (90%), 4.Үр ашигтай хамтын ажиллагааг тогтмолжуулах (100%).

**Дэд зорилт 4.4.**Шүүхийн үйл ажиллагаанд цахим технологи нэвтрүүлэх.

**Үйл ажиллагаа 4.4.1.**Кибер аюулгүй байдлыг хангах журам боловсруулж хэрэгжүүлэх;

**Үйл ажиллагаа 4.4.2.**Байгууллагын кибер аюулгүй байдлын сорил, программ хангамж нэвтрүүлэх;

**Үйл ажиллагаа 4.4.3.**Шүүхийн үйл ажиллагаанд шаардагдах программ хөгжүүлэх. 1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон бүртгэлийн үйл ажиллагаанд шаардагдах программ хөгжүүлэх (8), 2.Захиргааны менежментийн үйл ажиллагаанд шаардагдах программ хөгжүүлэх (1), 3.Хэргийн хөдөлгөөний программуудад нэмэлт хөгжүүлэлт хийх (1), 4.Их өгөгдөлд суурилсан шүүхийн шийдвэрийг таамаглах хиймэл оюун ухааны программ хөгжүүлэх (1);

**Үйл ажиллагаа 4.4.4.**Үүлэн технологид суурилсан хадгалах сан үүсгэх.

**ЗОРИЛТ 5.ШҮҮГЧ, АЖИЛТНЫ ХАРИУЦЛАГА, МЭРГЭЖЛИЙН ЦОГЦ ЧАДАМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ.**

**Дэд зорилт 5.1.**Шүүгчийн мэдлэг, ур чадвар, манлайллыг нэмэгдүүлэх.

**Үйл ажиллагаа 5.1.1.**Шүүгчийн манлайлал, академик ажлыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх;

**Үйл ажиллагаа 5.1.2.**Шүүгчийн ёс зүйн сургалтыг тогтмолжуулах;

**Үйл ажиллагаа 5.1.3.**Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт тогтмол зохион байгуулах;

**Үйл ажиллагаа 5.1.4.**Шүүхийн талаарх иргэд, оюутан, сурагчдын эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг тогтмолжуулах;

**Үйл ажиллагаа 5.1.5.**Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын албан ёсны орчуулгаар шүүгчдийг хангаж, хэрэглэх шаардлага, ур чадварыг дээшлүүлэх;

**Үйл ажиллагаа 5.1.6.**Шүүгч хэрэг, маргааныг хуульд үндэслэн хараат бус, шударгаар шийдвэрлэх мэргэшлийн ур чадварыг хөгжүүлэх.

**Дэд зорилт 5.2.**Шүүхийн захиргаанд ёс зүй, цогц чадамжтай хүний нөөц бүрдүүлэх, хөгжүүлэх.

**Үйл ажиллагаа 5.2.1.**Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх;

**Үйл ажиллагаа 5.2.2.**Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр хэрэгжүүлэх;

**Үйл ажиллагаа 5.2.3.**Шинэ ажилтныг дасан зохицуулах хөтөлбөр хэрэгжүүлэх;

**Үйл ажиллагаа 5.2.4.**Шүүгчийн туслах бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх;

**Үйл ажиллагаа 5.2.5.**Шүүхийн захиргааны хүний нөөцийг мэргэшүүлэх, давтан сургах чиглэлээр их, дээд сургууль, бусад мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах;

**Үйл ажиллагаа 5.2.6.**Хүний нөөцийг шилж олох, сонгон шалгаруулах, сургаж хөгжүүлэх, шатлан дэвшүүлэх, тогтвортой ажиллуулах.

-----oOo-----